

ӨМНӨХ ҮГ

Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэг, Хүн Амын Сургалт Судалгааны Төвтэй хамтран НҮБ-ын Хүн Амын Сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 9 дахь дугаарыг бэлтгэн эрхэм уншигч та бүхэнд толилуулж байна.

Манай сэтгүүлийн энэ удаагийн дугаар нь Монгол Улсын Үндэсний Статистикийн Газар байгуулагдсаны 80 жилийн оид зориулагдаж байна.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарын “Судалгаа” хэсгээс ахмад настнуудад учирч буй дарамт, бэрхшээл, Монгол улсын хүн амын ажил эрхлэлтийн өнөөгийн байдал, хүсээгүй жирэмслэлт ба үр хөндөлтийн шалтгаан зэрэг эрдэмтэн судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудын үр дүн, тэдгээрээс гарсан дүгнэлт зөвлөмжүүдтэй танилцах болно. Түүнчлэн хөдөө орон нутгийн судлаачийн өөрийн аймагтаа хийсэн шинжилгээ, судалгааны бүтээлийг нийтэлж байна. Мөн сэтгүүлийн “Сургалт” хэсгээс та бүхэн далд эдийн засгийн мөн чанар, арга зүйн асуудал, өрхийн хэрэглээг тодорхойлох, хүн амын дотоод шилжих хөдөлгөөн зэрэг онол арга зүйн бүтээлүүдтэй танилцах болно.

Монгол Улсын хүн ам, хөгжлийн асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оюун ухаан, мэдлэг чадвараа зориулж буй нийт эрдэмтэн судлаачид, мэргэжилтэн оюутан залуучууд та бүхэндээ мөн сэтгүүлийн дугааруудыг бэлтгэн хэвлэхэд байнгийн дэмжлэг, туслалцаа үзүүлж байдаг НҮБ-ын Хүн Амын Сангийн Суурин төлөөлөгчийн Газарт сэтгүүлийн редакцийн нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ